



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Үнэт цаас гаргах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 05 сарын 31-ний өдрийн 220 дугаар тогтоолын 1.1, 1.2 дахь хэсэг, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.16 дахь заалтыг тус тус үндэслэн “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн биржийн бус зах зээлд арилжаалагдах хаалттай Үнэт цаас (цаашид “Бонд” гэх)-ийг дараах ерөнхий нөхцөлөөр гаргасугай. Үүнд:

Төрөл:	Хаалттай бонд
Бондын нэр:	TOSK bond
Арилжаалах зах зээл:	Биржийн бус зах зээл
Татан төвлөрүүлэх дүн:	180,500,000,000 төгрөг
Нийт гаргах ширхэг:	180,500
Бондын нэрлэсэн үнэ:	1,000,000 төгрөг
Жилийн хүү:	8.5% (Талууд харилцан тохиролцож хүүг өөрчлөх эрхтэй)
Бондын хугацаа:	60 сар (Талууд харилцан тохиролцож тухай бүр сунгах эрхтэй)
Үндсэн төлбөр хийгдэх:	Хугацааны эцэст
Хүү төлөх давтамж:	Хагас жил тутам
Бондын баталгаа:	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа
Бондын зарцуулалт:	Зээлийн дахин санхүүжилт (Хөгжлийн банкнаас авсан зээлийн гэрээний төлбөр төлөх)
Бонд гаргах хугацаа:	Биржийн бус зах зээлд арилжаалах зөвшөөрөл гарснаар

2. Хаалттай бонд гаргахтай холбоотойгоор бондын үүргийн гүйцэтгэлийг хангахад шаардлагатай барьцаа хөрөнгө (үл хөдлөх эд хөрөнгө)-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тогтоолын нэг дүгээр хавсралтаар батлагдсан үл хөдлөх эд хөрөнгүүдээс Бондын барьцаагаар хангагдах шаардлагад тохирох үл хөдлөх эд хөрөнгүүдийг барьцаалах, холбогдох барьцааны гэрээ, бонд худалдах, худалдан авах гэрээг байгуулах, бондын арилжаа, гүйлгээг хийх, бусад холбогдох баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулах, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд барьцааны гэрээ, барьцаалбарыг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Л.Батжаргал)-д даалгасугай.

132003370

26-r huraldaan.docx

4.Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой төлөх шимтгэл хураамжийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталж, холбогдох зардал гаргахыг Гүйцэтгэх захирал (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

5.Хаалттай бонд гаргах үйл ажиллагааг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Шинэхүү)-д, Гүйцэтгэх захирал (Л.Батжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

6.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 352 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


7.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



**“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн биржийн бус зах зээлд
арилжаалагдах үнэт цаасны барьцаа хөрөнгийн жагсаалт**

1. Нийслэлийн “Хан-Уул” дүүргийн 21 дүгээр хороонд байрлах “Буянт-Ухаа 2” хорооллын 558 айлын орон сууц;
2. Нийслэлийн “Сүхбаатар” дүүргийн 11 дүгээр хороонд байрлах “Хангай” хотхоны 222 айлын орон сууц;
3. Архангай аймаг дахь “Булганхангай” хороолол 120 айлын орон сууц;
4. Хэнтий аймагт байрлах “Шинэ Өндөрхаан” хорооллын 115 айлын орон сууц, “Хэнтий 30 айл”-ын 8 айлын орон сууц, “Бор-Өндөр”-ийн 17 айлын орон сууц;
5. Увс аймагт байрлах “Галданбошигт” хорооллын 105 айлын орон сууц;
6. Дархан-Уул аймагт байрлах “Наран” хотхоны 150 айлын орон сууц;
7. Сэлэнгэ аймагт байрлах “Мандал” хотхоны 102 айлын орон сууц;
8. Ховд аймагт байрлах “Бугат” хотхоны 114 айлын орон сууц;
9. Нийслэлийн “Чингэлтэй” дүүргийн 6 дугаар хороонд байрлах “ТОСК” ТӨХХК-ийн 3 давхар объект;
10. Нийслэлийн “Хан-Уул” дүүргийн 21-р хороо, Морингийн даваа, Залуус-1 хорооллын 150,000м2 газар;
11. Нийслэлийн “Хан-Уул” дүүргийн, 21-р хороо, Морингийн даваа, Залуус-1 хорооллын 20,000м2 газар,
12. Нийслэлийн “Хан-Уул” дүүргийн, 21-р хороо, Морингийн даваа, Залуус-1 хорооллын 400,000м2 газар,
13. Нийслэлийн “Багануур” дүүргийн 1-р хороонд байрлах 3000м2 газар;
14. Хэнтий, Хэрлэн, 3-р баг 968м2 газар.

.....оОо.....

**“Төрийн орон сууцны корпорацн” ТӨХХК-ийн биржийн бус зах зээлд
арилжаалагдах үнэт цаасны шимтгэл хураамжийн жагсаалт**

/Төгрөгөөр/

№	Байгууллага	Төрөл	Төлөх давтамж	Шимтгэл, хураамж
1	МУЦАЭХ	Бүртгэлийн хураамж	Нийт дүнгийн 0,05% (доод дүн 2 сая дээд дүн 10 сая)	10,000,000
		Өргөдөл хянах хөлс	тогтмол	1,000,000
		Арилжааны шимтгэл	Тухай бүр	-
2	ҮЦТХТ	Бүртгэлийн хураамж	Нийт дүнгийн 0,02% (доод дүн 1 сая дээд дүн 10 сая)	10,000,000
		Хадгаламжийн шимтгэл	Тогтмол жил бүр	400,000
		Арилжааны шимтгэл	Тухай бүр	-
3	УБЕГ	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг шинээр улсын бүртгэлд бүртгүүлэх	Барьцаагаар хангагдах үүргийн үнийн дүнгээс 0.05 хувь (барьцааны гэрээ тус бүрт заасан үнийн дүнгээс) Барьцаалбар: энгийн 3000 төгрөг (бүртгүүлэх барьцаалбарын тоогоор)	-
		Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд орсон нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх	Үйлчилгээний хураамж: 5000 төгрөг (барьцааны гэрээ тус бүрт) Барьцаалбар: энгийн 3000 төгрөг (бүртгүүлэх барьцаалбарын тоогоор)	-

.....оОо.....